

“АЙТУҮҮЛС” ХК-ИЙН 2019.04.24-НИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ



● “АЙТҮҮЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 24 -ний өдрийн 15:00 цагт Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу-49 Мэдээллийн технологийн үндэсний паркийн хурлын танхимд болох тул Хувьцаа эзэмшигчид та бүхнийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр нь: 2019 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр байна.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

- Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах
- Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө танилцуулах
- Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг танилцуулах
- ТУЗ-ийн гишүүд сонгох, төсвийг батлах
- “Синэт” ХХК-ийн хувьцааг худалдан авах

Хувьцаа эзэмшигчид хурлын материал, гарах шийдвэрийн төслүүд болон холбогдох баримт бичигтэй хамааралтай асуудлаар 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд өөрийн үйлчилгээ авч буй үнэт цаасны компаниуд болон “Айтүүлс” ХК-ийн төв оффисд буюу Мэдээллийн технологийн үндэсний паркын 103 тоотод ирж танилцах боломжтой.

Утас: 99059722, 75755585 (1)

И-мэйл: info@itools.mn

● ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэндээ энэхүү мэндчилгээ хүрэх өдрийн мэнд хүргэе.

Юуны өмнө мэдээллийн технологийн салбарын хөгжил болон “Айтүүлс” компанийн ирээдүйд итгэн манай компанийн хувьцааг эзэмшигч болсон Танд талархаж буйгаа илэрхийлье.

“Айтүүлс” хувьцаат компанийн 2018 оны үйл ажиллагааны үр дүн, амжилт ололт болон цаашид сайжруулан хөгжүүлэх ажлуудаа тайлагнах хариуцлагатай мөч бидний өмнө дахин ирж байна. 2018 он манай компанийн хувьд борлуулалтын орлого, харилцагчийн тоо, ашигт ажиллагаа зэрэг олон чухал үзүүлэлтээ багагүй хувиар нэмэгдүүлж чадсан амжилт дүүрэн жил байлаа.

Үүний нэгэн үр дүн нь Монголын Хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжааны хоёрдогч зах зээлийн жилийн нийт арилжааны идэвхийн үзүүлэлтээрээ “Айтүүлс” ХК 2019 онд Монголын Хөрөнгийн биржийн ТОП-20 индекст багтсан явдал юм.

Өнгөрсөн жилд Төлөөлөн удирдах зөвлөл нийт 8 удаа хуралдаж гүйцэтгэх удирдлагын баг болон ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, технологийн шинэчлэлт, түүний үйл ажиллагааны найдвартай байдлыг бэхжүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхтэй холбоотой чухал шийдвэрүүдийг гарган ажиллалаа.

Компанийн хөрөнгө оруулагчдын бүтцэд өөрчлөлт орж гадаадын хөрөнгө оруулалтын сан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээр орж ирсэн нь компанийн засаглал, ил тод байдал сайжрах, бусад гадаад хөрөнгө оруулагч нарын сонирхлыг татахад нөлөөлөх нэгэн чухал зүйл болсон гэж үзэж байна.

ТҮЗ-ийн хувьд өнгөрсөн онд компанийн хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг дээдлэн, хөрөнгө оруулалтын өгөөжийг өндөр байлгахад анхаарч, компанийн засаглал ил тод байдлыг нэмэгдүүлэхийг зорин ажилласан бөгөөд 2019 онд энэхүү чиг, зорилтоо баримтлан ажиллах болно.

Та бүгдийгээ дэмжин ажиллаж үнэтэй зөвлөгөө өгөн хамтран ажиллана гэдэгт итгэж буйгаа илэрхийлэхийн ялдамд 2019 онд дэвшүүлж байгаа зорилтоо хүрэхийн төлөө хичээл зүтгэлтэй, бүтээлч ажиллана гэж “Айтүүлс” ХК-ийн удирдлагууд болон нийт ажиллагсдадаа найдаж байгаагаа илэрхийлж байна.

Та бүхэнд өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

А.БАТТАМИР

● **ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ**

Мэдээлэл, харилцаа холбооны салбар нь өнөөгийн дэлхий дахины хөгжлийн чиг хандлагыг тодорхойлогч голлох салбар болон хөгжиж үлс орнуудын нийгэм, эдийн засаг хүний хөгжлийн хурдасгагч нэгэн хүчин болж, ач холбогдол нь өдрөөс өдөрт өсөн нэмэгдсээр байна.

Энэхүү эрчимтэй өсч буй салбарт тогтвортой, найдвартай, тасралтгүй үйл ажиллагаа явуулж олон нийтэд нээлттэй компаниудын нэг болсон Айтүүлс ХК-ийн эрхэм хувьцаа эзэмшигч та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна. 2018 он бидний хувьд хамт олныхоо хичээл зүтгэл, харилцагчдынхаа итгэл, хамтын ажиллагааны үр дүнд салбартаа тэргүүлэгчийн байр сууриа болон өмнөх ололт амжилтуудаа давуулан бататгаж ажилласан сайхан жил байлаа.

Мэдээллийн технологийн салбарын ач холбогдол болон бидний хүчин зүтгэлийг Төр засгаас үнэлэн Монгол улсын засгийн газраас жил бүр олгодог ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ШИЛДЭГ ИННОВАЦИ шагналыг Ерөнхий сайдаас гардан авсан нь бидний үйл ажиллагааг дэмжин урам хайрласан үйл явдал болсныг та бүхэндээ дуулгахад таатай байна.

Чанарт суурилсан үйлчилгээг гол болгож, компанийн засаглалын тогтолцоог тасралтгүй сайжруулан ажилласны үр дүнд “Айтүүлс” ХК-ийн нийт борлуулалтын орлого 2017 онтой харьцуулахад 13,43% өсч, харилцагчийн тоо 19,04% өссөн байна. Үүний дотор үндсэн үйл ажиллагааны орлого 2017 онд 559.7 сая байсан бол 117% өсч 1217.2 сая хүрсэн нь тайлант жилийн нэгэн гол үзүүлэлт байлаа.

2019 онд мэдээллийн аюулгүй байдал түүнийг бүрэн хангаж ажиллахын тулд техник, технологийн болон хүний нөөцийн чадамжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанараа дэлхийн энд зэрэгцүүлэхийн тулд зогсолтгүй хөгжиж цөөнгүй тооны төсөл хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

2019 онд дэвшүүлсэн зорилго, зорилтдоо хүрэхийн тулд ирэх жилд бид хичээл зүтгэлтэй бүтээлч ажиллаж мэдээллийн аюулгүй байдал түүний үнэ цэнийг улам нэмэгдүүлэн ажиллахаа энэ завшааныг ашиглан нийт хөрөнгө оруулагчиддаа болон дотоод, гадаадын харилцагчиддаа илэрхийлж байна.

Та бүхэнд эрүүл энх, ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ТАМИР



ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЬЯ

АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 4 дахь заалт, "Айтүүлс" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Айтүүлс" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 15:00 цагт хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдөр, ХЭХурлын санал авах хуудас болон бусад холбогдох мэдээллийг хавсралтаар баталсугай.
3. Хурал зохион байгуулах комисс, тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр тус тус томилсугай.
 - Хурал зохион байгуулах комисс:
Дарга: А.Баттамир
Гишүүд: Г.Шаравдэмбэрэл, Ч.Энхбат
 - Хурлын тооллогын комисс:
Дарга: Л.Цэрэн-Очир
Гишүүн: Э.Онон
4. Хурал зохион байгуулах ажлыг хууль, журмын дагуу гүйцэтгэхийг хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  А.БАТТАМИР

● ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

#	ХӨТӨЛБӨР	ХАРИУЦАГЧ	ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА
1	Хурлын ирц бүртгэх	Зохион байгуулах комисс	20 мин
2	Хурлын ирцийг мэдээлэх	Тооллогын комисс	5 мин
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга	10 мин
4	Айтүүлс ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх	Гүйцэтгэх захирал	10 мин
5	Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө	Гүйцэтгэх захирал	10 мин
6	Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг танилцуулах	ТУЗ-ийн дарга	5 мин
7	СиНет ХХК компанийн хувьцааг шилжүүлэн авах тухай	Хурлын дарга	10 мин
8	ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга	Зохион байгуулах комисс, Тооллогын комисс	20 мин
9	Асуулт, хариулт	Хурлын дарга	30 мин
10	Санал хураалт	Тооллогын комисс	30 мин
11	Хурлын завсарлага, санал тоолох	Зохион байгуулах комисс, Тооллогын комисс	30 мин
12	Санал хураалтын дүнг танилцуулах	Тооллогын комисс	5 мин
13	Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах	Хурлын дарга	5 мин
14	Хурлыг хаах	Хурлын дарга	5 мин

Хурлын үргэлжлэх хугацаа: **3.30 цаг**

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.



● ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна. Мөн дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг байгуулж, компанийн засаглалыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2018 онд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нийт 8 удаа хуралдаж, “Айтүүлс” ХК-ийн үйл ажиллагаанд шаардлагатай асуудлуудаар нийт 14 тогтоол гарган компанийн стратегийг тодорхойлж, үйл ажиллагааг чиглүүлэн, хяналт тавьж ажиллалаа.

● ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



**Адилбиш
БАТТАМИР**

Дарга

- Техникийн ухааны магистр
- Нэр дэвшүүлэх хорооны гишүүн



**Гүндсамба
ШАРАВДЭМБЭРЭЛ**

Нарийн бичгийн дарга

- Цахилгаан холбооны ШУ-ны мастер
- Автомат цахилгаан холбооны инженер

● ХАРААТ БУС ГИШҮҮД



Дамдинсүрэн
ДАВАА

- Програм хангамжийн инженер
- ККТТ ХХК-ийн Бизнес хариуцсан захирал
- Цалин урамшууллын хорооны гишүүн



Зэсэм
МЯГМАРСҮРЭН

- Зах зээл судлаач, эдийн засагч
- Бодь тусгал Аудит ХХК-ийн захирал
- Аудитын хорооны дарга, цалин урамшууллын хорооны гишүүн



Энхтуяа
НАРАНМӨНХ

- Програм хангамжийн инженер
- Грийнсофт ХХК-ийн Борлуулалт, маркетингийн албаны дарга
- Нэр дэвшүүлэх хорооны гишүүн



Лхагва
ТЭМҮҮЛЭЛ

- Эрх зүйн ухааны магистр
- Тэлмэн хас ББСБ-ийн Хувьцаа эзэмшигч
- Нэр дэвшүүлэх хорооны дарга, аудитын хорооны гишүүн

● ЕРДИЙН ГИШҮҮД



Нанжид
УЛААНХҮҮ

- Эдийн засгийн онолч, эдийн засагч
- Аудитын хорооны гишүүн



Гантулга
ХАТАНБОЛД

- Санхүүгийн удирдлагын магистр
- Дижитал эксчейнж монголиа ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- Цалин урамшууллын хорооны дарга



Баярмагнай
ЭРДЭНЭЖАРГАЛ

- Бизнесийн удирдлага
- Стандарт инвестмент ҮЦК ХХК-д диллер

● КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД



Баярсайхан
ТАМИР

“Айтүүлс” ХК-ийн Гүйцэтгэх захирал

- Саман-Ёлу ХХК-д Захирлын туслах, Эмпати-Ертөнц ХХК-д нягтлан бодогч,
- Улаанбаатар-Элит ОУДС-д нягтлан бодогч
- ТЕГ-ын дэргэдэх НӨАТ-ын төсөл Ерөнхий санхүүч
- Гааль Татварын мэдээллийн технологийн төв УТҮГ-т олон нийттэй харилцах мэргэжилтэн
- Эмпасофт ХХК-д сургалт хариуцсан менежерээр тус тус ажиллаж байсан.
- 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн ТҮЗ-ийн 2018 оны 09 тоот тогтоолоор “Айтүүлс” ХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.



Туул
ЭНХЦЭЦЭГ

Нягтлан бодогч

- Бага баян ТӨҮГ-д нягтлан бодогч,
- Сиберри фарм продактс ХХК-д ерөнхий нягтлан бодогчоор тус тус ажиллаж байсан.
- 2018 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн “Айтүүлс” ХК-ийн Нягтлан бодогчоор ажиллаж байна.



Гүндсамба
ШАРАВДЭМБЭРЭЛ

ТҮЗ-ын нарийн бичгийн дарга

- Төрийн холбооны газарт холбооны техникч, хэлтсийн дарга, ерөнхий инженер,
- “МЦХ” ХК-д Сургалтын төвийн захирал, “Ай си ти групп” ХХК-д Сургалт хүний нөөцийн мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан.
- 2018 оны 09 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн “Айтүүлс” ХК-ийн ТҮЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

● ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

01 CAP

“ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭГЧ” КОМПАНИАР ШАЛГАРЛАА

МҮОНРТ-“Цагийн хүрдийн баатрууд” хэмээх ёслол хүндэтгэлийн ажиллагаанаас “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэгч” компаниар шалгарав.



04 CAP

“АЙТҮҮЛС” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ШИНЭЭР ТОМИЛОГДЛОО

“Айтүүлс” ХК-ийн гүйцэтгэх захирлаар 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс Баярсайханы Тамирыг томилон ажиллуулах ТУЗ-ийн тогтоол гарлаа.



04 CAP

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04 сарын 30-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн 90%-ийн ирцтэйгээр зохион байгуулагдаж хурал хүчин төгөлдөр болсон.



11 CAP

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ШИЛДЭГ ИННОВАЦИЙН АНХНЫ ШАГНАЛЫГ ХҮРТЛЭЭ.

Засгийн газрын 2018 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор “Үйлчилгээний салбарын шилдэг инноваци” шагналыг хүртэв.



● БУСАД ҮЙЛ ЯВДЛУУД

04 CAP

ЭРҮҮЛ МЭНДИЙН ОНОШЛОГОО ШИНЖИЛГЭЭНД БҮРЭН ХАМРАГДАВ.

"Гурван гал" эмнэлэгтэй хамтын ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх иж бүрэн үзлэгт нийт ажилчдаа хамруулав.



04 CAP

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТАНД ХАМРАГДЛАА.

Дата төв, Блокчэйн дата төв зэрэг өдөр тутамдаа цахилгааны өндөр хэрэглээтэй байдаг технологийн багийнхан галын аюул, эрсдэлийн эсрэг авах арга хэмжээнүүдийн талаар сургалтад хамрагдлаа.



05 CAP

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН УЛСЫН Х-Р ОЛИМПИАДАД ИВЭЭН ТЭТГЭГЧЭЭР ОРОЛЦЛОО.

Монголын хүний нөөцийн менежментийн улсын олимпиад нь бизнес менежмент, эдийн засгийн чиглэлээр сургалт явуулдаг их дээд сургуулиудын дунд жил бүр зохион байгуулагддаг.



05 CAP

STARTUP & STANDUP ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ.

STARTUP & STANDUP үйлчилгээг гарааны бизнес эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгч нарт зориулан 2018/05 сард үйлчилгээнд нэвтрүүлж эхэлсэн.



06 CAP

I EVENT УУЛЗАЛТ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

Блокчэйн технологийн ирээдүйн хөгжил, түүний хэрэглээний талаар мэргэжлийн экспертүүдээс туршлага судлах, суралцах боломжийг I EVENT уулзалт зохион байгуулав.



08 CAP

ДЭЛХИЙН СЭТГҮҮЛЧ “АЙТҮҮЛС”-Д

Япон улсын хамгийн том, хэвлэл мэдээллийн “Nikkei” компанийн нийтэлснээр “Айтүүлс” ХК Япон улсад шилэн кабелиар нүүрсээ экспортолж буй талаарх мэдээ дэлхий дахины анхаарлыг татсан үйл явдал болсон билээ.



09 CAP

“АЙСИТИ ЭКСПО” 2018-Д ОРОЛЦЛОО.

2018/09/30-нд клауд болон дата центрийн шийдлээр оролцож, үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцууллаа.



11 CAP


“ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИ 2018” ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦЛОО.

2018.11.21 - 2018.11.22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Шинжлэх ухаан, технологи, инноваци 2018” үзэсгэлэнд оролцлоо.




2018 онд Борлуулалтын орлого 13.4%-аар өсч 1,512.8 сая төгрөгт хүрсэн бол үүний дотор Үндсэн үйл ажиллагааны орлого 117.5%-аар өсч 1,217.2 сая төгрөгт хүрсэн байна.

ББӨ харьцангуй өндөр Үндсэн бус үйл ажиллагааны орлогын эзлэх хувь буурсантай холбоотойгоор ББӨ 29.8%-аар буурсан байна. Ийнхүү орлогын өсөлт болон ББӨ-ийн бууралттай холбоотойгоор ашгийн хэмжээ 171.3 сая болж өмнөх оноос 2.7 дахин өслөө.



Ашгийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор хувьцаанд ногдох ашиг (EPS) 4.97 төгрөгт хүрч өмнөх оноос 2.7 дахин өссөн байна.

Ийнхүү EPS өссөнөөр P/E буюу үнэ ашгийн харьцаа 19.5 болж сайжирсан байна.



Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 4.8% болж өмнөх оноос 2.4 дахин өссөн бол Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 5.7% болж өмнөх оноос 2.6 дахин өсчээ.



● **СТАТИСТИК МЭДЭЭ /2017 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХАРЬЦУУЛАВ/**

Борлуулалтын орлого

1,512 тэрбум төгрөг 13,43% ↑

Цэвэр ашиг

171,3 сая төгрөг 172% ↑

Дотоодын зах зээл дээрх борлуулалт

1,217 тэрбум төгрөг 117% ↑


Харилцагчдын тоо

6319 19.04% ↑

Ажилтны тоо

24 47% ↑

2018 онд Мэдээлэл холбооны салбарын ДНБ өсөлт 4% байсан бөгөөд “Айтүүлс” ХК-ийн хувьд дотоодын зах зээлийн 28 орчим хувийг эзэлж байна.



Дунджаар 1 харилцагч 3-5 бүтээгдэхүүн, үйлчилгээ авч ашиглаж байна.

● **2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Компанийн нийт борлуулалтын орлогыг өмнөх оноос 50% өсгөх
- Олон улсын TIER 3 стандартыг хангаж, найдвартай, тасралтгүй ажиллагааг 99.982%- дээр тогтворжуулах
- Олон улсын PCI DSS стандартыг нэвтрүүлсэнээр Санхүүгийн дата төвийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах
- Мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах
- Нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх
- Хүний нөөцийг чадавхижуулах
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

● ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР



2018/09

САНХҮҮГИЙН ДАТА ТӨВИЙН ӨРГӨТГӨЛИЙН АЖИЛ ЭХЛЭЛЭЭ.

“Айтүүлс” ХК нь 2018 онд хэд хэдэн томоохон төсөл хэрэгжүүлж байгаагийн нэг нь “Санхүүгийн дата төв”-ийн төсөл юм.

2018/09

PCI DSS СТАНДАРТ НЭВТРҮҮЛЭХЭЭР БОЛЛОО.

Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар PCI DSS стандарт нэвтрүүлэхээр боллоо.



2018/09

БЛОКЧЭЙН ДАТА ТӨВИЙГ АШИГЛАЛТАНД ОРУУЛЛАА.

Дархан хотод Блокчэйн дата төвийг ашиглалтанд оруулж Япон улсын компаниудтай хамтран ажиллаж байна.

2018/11

КЛАУД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨГЖҮҮЛЭЛТ ЭХЭЛЛЭЭ.

Орчин үеийн дата төвийн чиг хандлага, трэнд болсон үүлэн тооцооллын технологийг нэвтрүүлж Үндэсний клауд үйлчилгээг нээх ажлыг эхлүүллээ. Энэхүү үйлчилгээ нь 2019 оны 06 сараас хэрэглээнд нэвтрэх юм.



2018/11

ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгждэг Экспортыг дэмжих төслийн сонгон шалгаруулалтанд шалгарч тус төслийн ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2018/11

ADB – /ASIAN DEVELOPMENT BANK/-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА.



● ХАМТЫН АЖИЛЛАГАА /Гадаад/



2018/04

IBM КОМПАНИЙН АЛБАН ЁСНЫ ТҮНШ КОМПАНИ БОЛЛОО.

Монгол улсад ихээхэн дутагдаж буй санхүүгийн дата өгөгдлийн аюулгүй байдал, блокчэйн технологи дээр суурилсан дэд бүтэц хөгжүүлэлт дээр цаашид хамтран ажиллахаар болж хамтын ажиллагааны гэрээ үзэглэлээ.

2018/04

RACKCORP КОМПАНИЙН МОНГОЛ ДАХЬ АЛБАН ЁСНЫ ТӨЛӨӨЛӨГЧ БОЛЛОО.

Олон улсад үйл ажиллагаагаа явуулдаг Rackcorp компанитай хамтын ажиллагаагаа эхлүүлж Монгол дахь албан ёсны төлөөлөгч боллоо.



2018/04

БЛОКЧЭЙН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭКСПОРТОЛЖ ЭХЭЛЛЭЭ

“Айтүүлс” ХК нь Япон улсын мэдээллийн технологийн тэргүүлэх компани болох UNIMEDIA групп компанитай “Хамтын ажиллагааны гэрээ” үзэглэлээ.

2018/07

ЯПОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД АЙТҮҮЛС ХК КЛАУДМАЙНИНГ ҮЙЛЧИЛГЭЭГ ЭКСПОРТОЛЖ ЭХЭЛЛЭЭ.

Япон улсын мэдээллийн технологийн компани тэр дундаа блокчэйн технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлдэг “Гинко Монгол” компанитай бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хамтран ажиллах талаар хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.



2018/10

AFC /ASIA FRONTIER FUND/ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН АЙТҮҮЛС ХК-ИЙН СТРАТЕГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ БОЛЛОО.

2018 оны 10-р сарын 05-нд AFC нь “Айтүүлс” ХК-ийн хувьцааны 11.92%-ийг худалдан авч, эрх бүхий хувьцаа эзэмшигч болсноор Монгол улсын Мэдээлэл технологийн салбарт оруулж буй томоохон хөрөнгө оруулалт болсон.



2018/11

ҮНДЭСНИЙ БЛОКЧЭЙН ПЛАТФОРМ “ЖАМУХА”-ЫН ДЭД БҮТЦИЙГ ХАРИУЦАН АЖИЛЛАХААР БОЛЛОО.

Жамуха платформ нь Монгол залуусын оюуны инноваци шингэсэн бүтээл ба блокчэйн технологид суурилж, бизнесийн бүхий л салбарт үнэ цэнэ, шударга өрсөлдөөнийг бий болгох шинэ үеийн сүүрч технологи юм.



АУДИТ ХЯНАЛТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 02 сарын 18 өдөр

Дугаар _01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 1, 2 дахь заалт, “Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

3. “Айтүүлс” ХК-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, санхүүгийн дата төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 2018 оны ашигаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

4. Шийдвэртэй холбоотой мэдээллийг хууль, тогтоомжид заасан хугацаанд холбогдох байгууллага болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Б. Тамир/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

А.БАТТАМИР

"Айтүүлс" ХК
Санхүүгийн тайлангийн аудит
2018 оны 12 дугаар сарын 31-нээрт дүгсгөвөр болсон

"Төвдөн нэгж Аудит" ХХК

"АЙТҮҮЛС" ХК
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭРХ
(төгрөгөөр)

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Үзүүлэлт	2017.12.31	2018.12.31	Залруулга	Аудит хийгдсэн дүн
1. Богино хугацаат өр төлбөр				
Дансны өглөг	29,314,467.43	60,175,907.30		60,175,907.30
Цалингийн өглөг		3,918,681.22		3,918,681.22
Татварын өглөг	49,191,617.01	121,357,313.20	(1,042,293.01)	120,315,020.19
НДШ-ийн өглөг	39,459.56	3,165,291.79		3,165,291.80
Хүүгийн өглөг				
Ногдол ашгийн өглөг				
Банкны богино хугацаат зээл	13,831,400.00			-
Нөөц /өр төлбөр/				-
Бусад богино хугацаат өр төлбөр		173,168,708.51		173,168,708.51
Урьдчилж орсон орлого	242,620,485.29	245,745,030.17		245,745,030.17
Богино хугацаат өр төлбөрийн дүн	334,997,429.29	607,530,932.20	(1,042,293.01)	606,488,639.19
2. Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат зээл				
Бусад урт хугацаат өглөг	-	-		-
Хойшлогдсон татварын өр			1,042,293.01	1,042,293.01
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-	1,042,293.01	1,042,293.01
Өр төлбөрийн нийт дүн	334,997,429.29	607,530,932.20	-	607,530,932.20
Эзэмшигчдийн өмч				
Өмч: а) Төрийн				
б) Хувийн	905,758,223.28	905,758,223.28		905,758,223.28
в) хувыцаат	1,338,798,000.00	1,338,798,000.00		1,338,798,000.00
Хувыцаат капиталын дүн	2,244,556,223.28	2,244,556,223.28		2,244,556,223.28
Нэмж төлөгдсөн капитал				-
Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	460,721,652.19	460,721,652.19		460,721,652.19
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц				-
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	116,971,238.26	288,273,478.79		288,273,478.79
Эзэмшигчдийн өмчийн дүн	2,822,249,113.73	2,993,551,354.26		2,993,551,354.26
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН €	3,157,246,543.02	3,601,082,286.46	-	3,601,082,286.46

Хавсаргасан тайлангууд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

12

"Айтүүлс" ХК
 Санхүүгийн тайлан/үйтгэл
 2018 оны 12 дугаар сарын 31-н өдөр дууссанар байсан

"Талын тэжээл Архан" ХУА

"АЙТҮҮЛС" ХК
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭРХ
 (төгрөгөөр)

ХӨРӨНГӨ	Үзүүлэлт	2017.12.31	2018.12.31	Залруулга	Аудит хийгдсэн дүн
1. Эргэлтийн хөрөнгө					
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө		412,008,757.57	28,763,843.20		28,763,843.20
Дансны авлага		40,741,491.57	181,146,590.54		181,146,590.54
Бусад авлага		116,583,296.57	321,188,924.98		321,188,924.98
Барва материал		61,762,184.46	90,355,536.92		90,355,536.92
Бусад эргэлтийн хөрөнгө					-
Урьчилж төлсөн зардал/гооцоо		195,474,120.68	520,510,397.89		520,510,397.89
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг)					-
Эргэлтийн хөрөнгийн дүн		826,569,850.85	1,141,965,293.53		1,141,965,293.53
2. Эргэлтийн бус хөрөнгө					
Үндсэн хөрөнгө		2,203,853,316.26	2,256,421,417.02		2,256,421,417.02
Биет бус хөрөнгө		56,377,230.91	132,249,430.91		132,249,430.91
Биологийн хөрөнгө					-
Урт хугацаат хөрөнгө оруулалт		70,446,145.00	70,446,145.00		70,446,145.00
Хайгуул үнэлгээний хөрөнгө					-
Хойшлогдсон татварын хөрөнгө					-
Хөрөнгө оруулалт/бн зориулалттай үл хөдлөх хөрөнгө					-
Бусад эргэлтийн бус хөрөнгө					-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		2,330,676,692.17	2,459,116,992.93		2,459,116,992.93
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		3,157,246,543.02	3,601,082,286.46		3,601,082,286.46

Хангалдсан амьдрал/түүг нь энхүү тайлан/үйтгэл дээр үндэслэн болно.

//

"Айтүүлс" ХК

Санхүүгийн тайлангийн аудит

2018 оны 12 дугаар сарын 31-нээрх дуусгавар болсон

"Голден гейтс Аудит" ХХК

"АЙТҮҮЛС" ХК
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭРХ
(тогрогөөр)

	2017.12.31	2018.12.31	Аудит хийгдсэн дүн
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,333,663,971.57	1,512,815,765.71	1,512,815,765.71
Хөрөнгө оруулалтын орлого			
Бусад орлого			
Борлуулалтын орлогын дүн	1,333,663,971.57	1,512,815,765.71	1,512,815,765.71
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	851,449,899.49	597,985,826.33	597,985,826.33
Нийт ашиг (алдагдал)	482,214,072.08	914,829,939.38	914,829,939.38
Түрээсийн орлого	9,090,909.09	10,909,090.91	10,909,090.91
Хүүгийн орлого	1,147,298.06	428,578.78	428,578.78
Ноогдол ашгийн орлого			
Эрхийн шимтгэлийн орлого			
Бусад орлого		162,250.61	162,250.61
Борлуулалт маркетингийн зардал			
Ерөнхий ба удирдлагын зардал	431,567,892.06	742,679,505.80	742,679,505.80
Санхүүгийн зардал			
Бусад зардал /ҮАБЗ/		7,732,045.00	7,732,045.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/	9,062,055.75	5,945,174.58	5,945,174.58
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		9,331,455.45	9,331,455.45
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/			
хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз/гарз/			
Бусад ашиг /алдагдал/			
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	69,946,442.92	191,194,938.91	191,194,938.91
Орлогын татварын зардал	6,994,644.29	19,892,698.39	19,892,698.39
Тайлант үеийн орлогын татварын зардал	6,994,644.29	19,892,698.39	19,892,698.39
Хойшлогдсон татварын зардал /орлого/			
Татварын дараах ашиг /алдагдал/	62,951,798.63	171,302,240.52	171,302,240.52
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	62,951,798.63	171,302,240.52	171,302,240.52
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүүний нөөц			
Бусад олз /гарз/			
Орлогын нийт дүн	62,951,798.63	171,302,240.52	171,302,240.52
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/			

Хэвсгэсэн тэмдэглэлүүд нь ажгуу тайлангийн сэлтгүй хэсэг болно.



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.9 дэхь заалт, “Айтүүлс” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 04 дугаар сарын 24 -ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

А.БАТТАМИР

**“АЙТҮҮЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: _____

Регистерийн дугаар: _____

Санал өгөх хувьцааны тоо: _____

Бүртгэсэн /Үнэт цаасны компани/: _____

Брокерийн овог, нэр: _____

“АЙТҮҮЛС ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4-р сарын 24 -ний өдрийн 15.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, МТҮПаркын Хурлын танхимд болно.

#	ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД	ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ	ЗӨВШӨӨРСӨН	ТАТГАЛЗСАН	ТҮДГЭЛЗСЭН
1	Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах				
2	Компанийн 2019 оны төлөвлөгөө				
3	Төлөөн удирдах зөвлөлийн гишүүд, тэдний цалин урамшууллын төсөл батлах				
4	Синэт -ХХК -ийн хувьцааг худалдан авах				
5	Бусад асуудал				

Брокер /гарын үсэг/

/тэмдэг/

Хувьцаа эзэмшигч /гарын үсэг/

Огноо: ____ оны __ сарын __ өдөр

**“АЙТҮҮЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: _____

Регистерийн дугаар: _____

Санал өгөх хувьцааны тоо: _____

Бүртгэсэн /Үнэт цаасны компани/: _____

Брокерийн овог, нэр: _____

#	ТҮЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО
1	Ердийн гишүүд	
2		
3		
4		
5		
6		
7		
8		
	Хараат бус гишүүд	
1		
2		
3		
4		
5		

Брокер /гарын үсэг/

/тэмдэг/

Хувьцаа эзэмшигч /гарын үсэг/

Огноо: ____ оны __ сарын __ өдөр

ТҮЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшидэг гэвэл тус компанийн ТҮЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Таны эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТҮЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТҮЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцан санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 99059722 утсаар лавлаж болно.
4. Санал авах хуудас хүчингүй болсон тухай шалтгаан